



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Хүрээлэн буй орчны тэмдэг ба мэдэгдэл –
Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загвар - Зарчмууд ба журмууд**

MNS (ISO) 14024 : 99

АЛБАН ХЭВЛЭЛ

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Улаанбаатар хот

1999 он

Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) нь үндэсний стандартчиллын байгууллагуудын (ОУСБ-ын гишүүн байгууллагуудын) дэлхий дахины холбоо юм. Олон улсын стандарт боловсруулах ажлыг ОУСБ-ын техникийн хороодоор дамжуулан хийдэг. Тухайн техникийн хорооны хариуцах асуудлыг сонирхсон гишүүн байгууллага бүр уг хороонд төлөөлөлтэй байх эрхтэй.

Түүнчлэн ОУСБ-тай харилцаа бүхий засгийн газрын болон засгийн газрын бус олон улсын байгууллагууд уг ажилд оролцдог.

ОУСБ нь цахилгаан техникийн стандартчиллын салбарт Олон улсын цахилгаан техникийн комисс (ОУЦТК)-той нягт хамтран ажилладаг.

Техникийн хороодоос сайшаасан олон улсын стандартуудын төслийг гишүүн байгууллагуудад тарааж санал хураадаг. Тэдгээрийг олон улсын стандарт болгож хэвлэхийн тулд санал хураалтад оролцсон гишүүн байгууллагуудын наад зах нь 75%-ийн дэмжлэгийг авах шаардлагатай.

ИСО 14024 Олон улсын стандартыг *Хүрээлэн буй орчны удирдлагын* асуудал хариуцсан 207-р Техникийн хорооны *“Хүрээлэн буй орчны тэмдэглэгээ”* хэмээх 3-р дэд хорооноос боловсруулсан болно.

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв (СХҮТ)

Энх тайвны өргөн чөлөө 46А.

Улаанбаатар 211051, Ш/Х - 48

Утас 457763 457765. Факс (976-1) 458032.

E-mail:mncsm@magicnet.mn

© СХҮТ 1999

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХҮТ (Стандартчилал баталгаажуулалтын төв байгууллага) - д байна.

ОРШИЛ

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хэд хэдэн чиглэлүүд байдаг.

Энэхүү олон улсын стандарт нь хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн 1-р загварт хамаарна. Уг хөтөлбөрийн хүрээнд урьдчилан тогтоосон шаардлагыг хангаж буй бүтээгдэхүүнд хүрээлэн буй орчны тэмдгийг олгодог. Иймд хүрээлэн буй орчны тэмдэг нь тухайн бүтээгдэхүүний ангилалд багтаж байгаа хүрээлэн буй орчинд нийцсэн бүтээгдэхүүнийг тодорхойлно.

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн 1-р загвар нь сайн дурын шинж чанартай бөгөөд үүнийг олон нийтийн, хувийн агентлагууд үндэсний, бүс нутгийн ба олон улсын шинж чанартайгаар хэрэгжүүлж болно.

Агуулга	Хуудас
1 Хамрах хүрээ	1
2 Норматив ишлэл	1
3 Нэр томъёо ба тодорхойлолт	1
4 Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1- загварын зорилго	3
5 Зарчмууд	3
6 Журмууд	7
7 Батлагаажуулалт ба нийцэл	11
Номзүй	14

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 03.040

Хүрээлэн буй орчны тэмдэг ба мэдэгдэл – Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загвар – Зарчмууд ба журмууд	MNS (ISO) 14024 :99
Environmental labels and declarations – Type 1 environmental labelling – Principles and procedures	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төвийн Зөвлөлийн 1999 оны 11 дүгээр сарын 30 -ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 1999 оны 12 дугаар сарын 01 -ны өдрөөс мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү олон улсын стандарт нь бүтээгдэхүүний ангиллыг сонгох, бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт, бүтээгдэхүүний шинж чанарыг тодорхойлох асуудлуудыг хамарсан хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварыг боловсруулах, шаардлагад нийцэж буйг үнэлэх, баталгаажуулахад зориулсан үндсэн зарчмууд ба журмуудыг тогтооно. Түүнчлэн хүрээлэн буй орчны тэмдгийг олгох баталгаажуулалтын журмыг тогтооно.

2 Норматив ишлэл

Дараах норматив бичиг баримт нь энэхүү олон улсын стандартын шаардлагыг тогтоосон заалтуудыг агуулна. Иш татсан норматив баримт бичгийн он сар өдрийг заасан тохиолдолд холбогдох нэмэлт, дахин хяналт болон сүүлчийн хэвлэлийг хэрэглэхгүй. Гэхдээ энэхүү олон улсын стандартын үндсэн дээр гэрээ хийж буй талууд нь дор заасан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэж болно.

ISO 14020:98, *Хүрээлэн буй орчны тэмдэг ба мэдэгдэл – Ерөнхий зарчмууд*

3 Нэр томъёо ба тодорхойлолт

Энэхүү олон улсын стандартад дараах нэр томъёо тодорхойлолтыг хэрэглэж болно.

3.1

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн 1-р загвар

Сайн дурын шинж чанартай, олон талын үзүүлэлтэд үндэслэсэн хөндлөнгийн этгээдээс боловсруулсан хөтөлбөр. Энэ хөтөлбөр нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгт үндэслэсэн тухайн бүтээгдэхүүний ангилал дотор багтаж буй тэр бүтээгдэхүүнд хүрээлэн буй орчны талархи боломжтой бүх мэдээллийг тусгасан хүрээлэн буй орчны тэмдгийг хэрэглэх эрхийн зөвшөөрөл олгоно.

3.2

Бүтээгдэхүүн

Аливаа бараа ба үйлчилгээ.

3.3

Бүтээгдэхүүний ангилал

Ижил үүрэгтэй бүтээгдэхүүний бүлэг.

3.4

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт

Хүрээлэн буй орчны тэмдгийг бүтээгдэхүүнд олгохын тулд тавигдах хүрээлэн буй орчны шаардлагууд.

3.5

Бүтээгдэхүүний (үүрэг) зориулалтын шинж чанар

Бүтээгдэхүүний үзүүлэлт болон хэрэглээний үеийн шинж чанар.

3.6

Эко тэмдэглэгээний байгууллага

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн 1-р загварыг эрхлэн явуулах гуравдагч этгээдийн байгууллага буюу түүний албад.

3.7

Хөндлөнгийн этгээд

Тухайн асуудлаар оролцогч талуудын алинд нь чүл хамаарах, бие даан хүлээн зөвшөөрөгдсөн этгээд буюу байгууллага.

[ИСО Удирдамж 2:1996]

ТАЙЛБАР: “Оролцогч тал” гэдэгт нийлүүлэгч (нэг дэхь тал) ба худалдан авагч (хоёр дахь тал) байна.

3.8

Сонирхогч талууд

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн 1-р загварт нөлөөлж буй аливаа этгээд.

3.9

Гэрчилгээ эзэмшигч

Эко тэмдэглэгээний байгууллагаас хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварыг хэрэглэх эрх авсан этгээд.

3.10

Хүрээлэн буй орчны чиг баримтлал

Хүрээлэн буй орчинд харилцан нөлөө үзүүлж болох байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба үйлчилгээний элементүүд.

ТАЙЛБАР: Хүрээлэн буй орчны чухал чиглэл гэдэг нь хүрээлэн буй орчинд чухал нөлөө үзүүлэх чиглэлүүд юм.

[ИСО 14001:1996]

3.11

Хүрээлэн буй орчны нөлөөлөл

Байгууллагын Зохион байгуулалтын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба үйлчилгээний бүхэл эсвэл хэсэгчилсэнүр дүнгээс хамааран тааламжгүй болон үр өгөөжтэйгээр хүрээлэн буй орчинд нөлөөлөх аливаа өөрчлөлт.

3.12

Баталгаажуулалт

Гуравдагч этгэдээс бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ нь өгөгдсөн шаардлагад нийцэж буйг бичгээр баталсан үйл ажиллагаа.

[ИСО Удирдамж 2:1996]

3.13

Гэрчилгээ (хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварт зориулсан)

Баталгаажуулалтын тогтолцооны дүрмийн дагуу гаргасан баримт бичиг.

Уг баримт бичгийг эко тэмдэглээний байгууллагаас хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн дагуу бүтээгдэхүүн ба үйлчилгээндээ хүрээлэн буй орчны тэмдгийн 1-р загварыг хэрэглэх эрхийг хувь хүнд буюу байгууллагад олгоно.

3.14

Зорилгодоо нийцэх

Бүтээгдэхүүн, үйл явц буюу үйлчилгээ нь заасан нөхцлүүдийн дагуу тодорхойлогдсон зорилгоо биелүүлэх чадвар.

[ИСО Удирдамж 2:1996]

4 Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын зорилго

Хүрээлэн буй орчны тэмдэг ба мэдэгдлийн гол зорилго бол бүтээгдэхүүн ба үйлчилгээний хүрээлэн буй орчны чиг баримтлалыг төөрөгдөлд орохооргүй, баталгаатай үнэн зөв мэдээлснээр тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хүрээлэн буй орчинд бага хохирол учруулах, үүний үр дүнд зах зээлд чиглэсэн хүрээлэн буй орчныг байнга сайжруулах боломжийг дэмжих явдал юм.

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын зорилго нь 1-р загварын хөтөлбөрийн онцлог шалгуур үзүүлэлтэд нийцсэн бүтээгдэхүүнийг тодорхойлох замаар бүтээгдэхүүнтэй холбогдол бүхий хүрээлэн буй орчны нөлөөллийг багасгахад оршино.

Энэхүү олон улсын стандартын зорилго нь хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварыг хэрэгжүүлэхэд тодорхой, ойлгомжтой, бодит байдлыг хангах ба түүнчлэн хөтөлбөрт хэрэглэж болох зарчим, журмуудыг нийцүүлэхэд оршино.

5 Зарчмууд

5.1 Хөтөлбөрийн сайн дурын шинж чанар

Засгийн газрын санхүүжилттэй агентлагуудаас боловсруулан хэрэгжүүлж буй хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын хөтөлбөр нь сайн дурын шинж чанартай.

5.2 ИСО 14020 стандартай хобогдох нь

Энэхүү олон улсын стандартын шаардлагуудаас гадна ИСО 14020 стандартад заасан зарчмуудыг хэрэглэнэ. Энэ стандартын шаардлага нь ИСО 14020 стандартын шаардлагаас илүү онцлог шаардлагатай бол түүнийг хэрэглэнэ.

5.3 Хууль тогтоомжтой холбогдох нь

Хүрээлэн буй орчны тэмдгийн 1-р загварыг хэрэглэх эрхийн гэрчилгээ авах ба мөрдөх урьдчилсан нөхцлүүд нь хүрээлэн буй орчны болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байвал зохино.

5.4 Амьдралын мөчлөгийн асуудал

Хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн асуудлыг авч үзсэнээр хүрээлэн буй орчны нөлөөллийг багасгах, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шатны үед жирийн бус байдлаар шилжих нөлөөллийн зроилгод сайн талтай. Хэрэв бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг боловсруулахад түүний үйл ажиллагаа нь түүхий эдийг гарган авах, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх гэх мэт үйл явцыг хамарч байвал амьдарлын мөчлөгийн үе шатыг авч үзэх нь зүйтэй. Эдгээр хандлагуудаас өөр ямар нэг ялгаатай асуудал эсвэл хүрээлэн буй орчны талаар хязгаарлагдмал асуудал гарвал баталгаажуулах хэрэгтэй.

5.5 Шалгаруулалт

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт нь хэмжигдэх боломжтой хүрээлэн буй орчны нөлөөлөлд үндэслэсэн бүтээгдэхүүний ангилал дотор бусдаасаа хүрээлэн буй орчны боломжоороо ялгагдах бүтээгдэхүүнүүдийг тогтооно. Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны үзүүлэлт нь бүтээгдэхүүнүүдийн хоорондын ялгаа нь чухал ач холбогдолтой гэсэн бүтээгдэхүүнийг ялгана.

Бүтээгдэхүүнийг үнэлэхэд хэрэглэж байгаа сорилтын ба баталгаажуулалтын аргачлал нь нарийвчлалын өөр өөр түвшинтэй байна. Дээрхи ялгааг чухал ач холбогдолтой гэдгийг тодорхойлохын тулд нарийвчлалын түвшинг хэрэглэдэг.

5.6 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт

5.6.1 Амьдарлын мөчлөгийн асуудал

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг амьдарлын мөчлөгийн талаархи чиг баримтлал (6.4-өөс үзэх)-аас үүсэн гарсан мэдрэмжүүдэд үндэслэнэ.

5.6.2 Шалгуур үзүүлэлтийн үндэс

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт нь ашиглах боломжтой түвшинд байх ёстой бөгөөд хүрээлэн буй орчны нөлөөлөл, хэмжлийн чадвар, нарийвчлалтай холбогдолтой чиг баримтлалыг өгнө.

5.7 Бүтээгдэхүүний зориулалтын шинж чанар

Шалгуур үзүүлэлтийг боловсруулах явцад бүтээгдэхүүн нь зорилго, үзүүлэлтийн түвшиндээ нийцэж байгааг авч үзэх нь зүйтэй. Олон улс, бүс нутгийн ба үндэсний

стандартуудыг хөтөлбөрт хэрэглэхдээ ИСО 14020 стандартуудад тусгасан заалтуудыг мөрдөнө.

5.8 Хөтөлбөрийн шаардлагуудын хүчин төгөлдөр байх хугацаа

5.8.1 Мөрдөх хугацаа

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт болон бүтээгдэхүүний зориулалтын шаардлагуудыг бүтээгдэхүүний ангилал бүрд урьдчилан тогтоосон хугацааны дагуу тогтооно.

5.8.2 Дахин хянах хугацаа

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт болон бүтээгдэхүүний зориулалтын шаардлагуудыг урьдчилан тогтоосон хугацааны дотор дахин хянахдаа шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн, хүрээлэн буй орчны талаархи шинэ мэдээлэл болон зах зээлийн өөрчлөлтийг тооцно. Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт болон бүтээгдэхүүний зориулалтын шаардлагуудыг дахин хянаж үзэхдээ тэдгээрт өөрчлөлт оруулахад шаардлагагүй чиг хандлагыг авч үзнэ.

5.9 Зөвлөлгөө

Сонирхогч талуудын дунд албан ёсоор нээлттэй оролцох үйл ажиллагаа нь бүтээгдэхүүний ангилал, бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт болон бүтээгдэхүүний зориулалтын шинж чанаруудыг сонгон авах, хянан үзэх зорилгоос гадуур явагдана.

5.10 Нийцэл ба баталгаажуулалт

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрийн дагуу бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт болон бүтээгдэхүүний зориулалтын шинж чанаруудын бүх элементүүдийг эко тэмдэглэгээний байгууллагаас баталгаажуулсан байна.

Нийцэж буйг үнэлэх аргуудад дараах баримт бичгүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- ОУСБ ба ОУЦТК-ын стандартууд;
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандартууд;
- Бүс нутгийн ба үндэсний стандартууд;
- Дэвшилтэт лабораторийн хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг мөрдөж байгаа бусад аргууд (дэвшилтэт лабораторийн талаархи мэдээллийг ОУСБ/ОУЦТК-ын 17025 стандартаас үзэх);
- үйлдвэрлэлийн нотолгоо

5.11 Ил тод ойлгомжтой байдал

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх бүх үе шатанд түүнийг маш тодорхой ойлгомжтой байдлаар үзүүлэх ёстой. Ойлгомжтой гэдэг нь зохих үед хяналт хийх, санал тавихад сонирхогч талуудад өгөх боломжтой мэдээлэл юм. Саналыг авч үзэх тодорхой хугацаа өгнө. Эдгээр мэдээлэлд дараах асуудлууд орно. Үүнд:

- бүтээгдэхүүний ангилалыг сонгох;
- бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг сонгох, боловсруулах;
- бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарууд;
- сорилтын ба баталгаажуулалтын аргууд;

- баталгаажуулалт ба журам тогтоох;
- дахин хянах хугацаа;
- баталгаажуулалтын хугацаа
- тэмдэг олгоход үндэслэсэн нууц биш нотолгоо;
- хөтөлбөр боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр (жишээлбэл: татвар, засгийн газрын санхүүгийн дэмжлэг г.м)
- шаардлагад нийцсэн баталгаа.

Ил тод ойлгомжтой байдал нь 5.17-р зүйлийн шаардлагатай зөрчилдөж болохгүй.

5.12 Олон улсын худалдааны чиг баримтлал

Хүрээлэн буй орчны тэмдэглэгээний хөтөлбөрийн журам, шаардлагуудыг олон улсын худалдаанд шаардлагагүй саад тотгорыг үүсгэхэд нөлөөлөхөөр боловсруулж, батлаж, хэрэглэж болохгүй. Дэлхий Худалдааны Байгууллагын заавар, тайлбараас хэрэглэх боломжтойг авч үзэх нь зүйтэй.

5.13 Эрх авах боломж

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх хөтөлбөрт оролцох ба түүнийг хэрэглэх асуудал нь бололцоотой бүх өргөдөл гаргагч нарт нээлттэй. Өргөдөл гаргагч нь бүтээгдэхүүний ангилалд тавигдах хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бусад хөтөлбөрийн шаардлагыг хангаж байвал тэмдэг авах, хэрэглэх эрхийн зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

5.14 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийн шинжлэх ухааны үндэслэл

Шалгуур үзүүлэлтийг боловсруулах ба шалгаруулахдаа шинжлэх ухааны болон инженерчлэлийн асуудлуудад үндэслэнэ. Шалгуур үзүүлэлт нь хүрээлэн буй орчны боломжийн шаардлагуудыг тусгасан мэдээ, баримтад тулгуурлана.

5.15 Ашиг сонирхлын маргааныг таслах

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын хөтөлбөр нь цаг үеийн нөлөөлөлд автахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Хөтөлбөр нь ашиг сонирхлын маргааныг үүсгэхгүй байх санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан байна.

ТАЙЛБАР ОУСБ/ОУЦТК-ын Удирдамж 65-ын заалтуудыг анхаарч үзэх.

5.16 Үнэ ба төлбөр

Өргөдөл гаргах сорилт явуулахад төлбөртэй байж болно. Зарчмын хувьд тэмдгийг хэрэглэх эрх олгох, хэрэгжүүлэхэд үнэ, төлбөр нь хөтөлбөрийн бүх тооцоонд үндэслэгдсэн байх бөгөөд хүрээлэн буй орчны тэмдгийг хэрэглэх эрх авах боломжийг дээд зэрэгт хүргэхийн тулд үнийг аль болохоор бага байлгах хэрэгтэй. Аливаа үнэ нь өргөдөл гаргагч ба гэрчилгээ эзэмшигчид адил тэгш эрхтэй байна.

5.17 Нууц байдал

Нууц гэж тодорхойлогдсон бүх мэдээллийн нууц байдлыг бүртгэж хадгална.

5.18 Харилцан хүлээн зөвшөрөх

Итгэлцэл дээр үндэслэгдсэн харилцан хүлээн зөвшөөрлийг дэмжих хэрэгтэй. Сорилт, хяналт, тохирлын үнэлгээ, захиргааны журам болон шаардлагатай бол хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг харилцан хүлээн зөвшөөрч болно. Бүх зүйл ил тод ойлгомжтой байлгахын тулд бусад эко тэмдэглээний байгууллагатай хийсэн хүчин төгөлдөр мөрдөж буй харилцан хүлээн зөвшөөрлийн гэрээний талаархи мэдээллийг боломжийн хэмжээнд хийсэн байвал зохино.

6 Журмууд

6.1 Ерөнхий зүйл

Хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загвар нь дараах асуудлуудыг агуулсан дахин давтагдах үйл явц юм.

- сонирхогч талуудтай зөвшилцөх;
- бүтээгдэхүүний ангиллыг сонгох;
- бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг боловсруулах, дахин хянах, өөрчлөх;
- бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг тодорхойлох;
- баталгаажуулалтын журмууд ба хүрээлэн буй орчны хөтөлбөрийн засаг захиргааны бусад элементүүд;

6.2 Сонирхогч талуудтай зөвлөлдөх

Эко тэмдэглэгээний байгууллага нь сонирхогч талуудыг бүрэн оролцуулахын тулд албан ёсоор зөвлөлдөх механизмыг хэрэгжүүлбэл зохино.

Зөвлөлдөөн нь бүтээгдэхүүний ангиллыг сонгох, бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт, бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг тогтооход явагдах тасралтгүй үйл ажиллагаа юм. Сонирхогч талуудад тодорхой хугацаа олгох хэрэгтэй бөгөөд тэд ашиглаж байгаа мэдээллийн эх үүсвэр, нарийн тодорхой зүйлүүдийг мэдэж байвал зохино. Зөвлөлдөөний үйл ажиллагаа нь хөтөлбөрийн талаар тавьсан саналыг сонирхогч талууд анхааралтай хүлээн авч, зохих хариултыг өгөх бололцоог бүрдүүлнэ. Зөвлөлдөх явцад нэгдмэл саналд хүрэхийн тулд боломжтой хүчин зүтгэл гаргавал зохино.

6.3 Бүтээгдэхүүний ангиллыг сонгох

6.3.1 Бүтээгдэхүүний ангиллыг тогтоох боломжийн талаар судалгаа явуулах

Үйл явцын энэ үе шатанд бүтээгдэхүүний ангилал болон зах зээлийн шинж чанарын талаар судалгаа явуулбал зохино. Судалгааны зорилго нь бүтээгдэхүүний ангиллыг авч үзэхэд оршино. Судалгаанд дараах зүйлүүд багтана. Үүнд:

- боломжтой бүтээгдэхүүний ангиллыг анхлан сонгох;
- сонирхогч талуудтай зөвлөлдөх;
- зах зээлийн судалгаа (жишээлбэл: шинж чанар, хэмжээ, эрэлт хэрэгцээ);
- зах зээл дэх нийлүүлэгч (жишээлбэл: жижиг, дунд үйлдвэр болон гадаад, дотоодын үйлдвэрлэгчид);
- бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны нөлөөлөл;
- хүрээлэн буй орчныг сайжруулах боломж ба хэрэгцээ шаардлага;

- бүтээгдэхүүний ангиллын хамрах хүрээг тодорхойлох (хэрэгцээг адил тэнцүү тооцно)
- хэрэглэх хэрэгцээнд нийцэх (бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарууд орно)
- мэдээ, баримтын үр ашиг;
- үндэсний ба олон улсын хүчин төгөлдөр байгаа хууль, гэрээ.

6.3.2 Бүтээгдэхүүний ангиллын талаархи санал

Бүтээгдэхүүний ангиллыг тогтоох боломжийн талаархи судалгааг бүрэн хийсэн тохиолдолд эко тэмдэглэгээний байгууллага нь ямар ангилалтай бүтээгдэхүүн зах зээл дээр хамгийн их эрэлт хэрэгцээтэй болохыг тогтоох байр суурьтай болно. Бүтээгдэхүүний ангиллын талаархи саналыг бүтээгдэхүүний ангилал тогтоох судалгаа түүний дүгнэлт хөтөлбөрт тусгах, бүтээгдэхүүний ангиллын чиг хандлага зэргийг нэгтгэж байгаа сонирхогч талуудад бэлтгэж өгнө.

6.4 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг сонгон авах боловсруулах

6.4.1 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг сонгон авах

1-р хүснэгтэд үзүүлсэн загвар бол энэ хүрээлэн буй орчны чиг хандлагыг хэрэглэх жишээ бөгөөд бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг сонгон авч эхлэхэд эко тэмдэглэгээний байгууллагад дэмжлэг үзүүлэхэд зориулсан болно. Маягт нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шатыг хүрээлэн буй орчны оролт, гаралтыг заагчтай холбож өгнө. Ялгаралтыг заагчийг арга хэрэгслээр нь бүлэглэх бөгөөд ихэвчлэн хэрэгсэл бүрд нэгээс их байна.

Энэхүү олон улсын стандартад заасан хамрах хүрээ ба журмууд нь эко тэмдэглэгээний байгууллага сонирхогч талуудын хоорондын зөвлөлдөх явцын үр дүнд эцсийн байдлаар тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг дагаж мөрдөхөд нэгдмэл загварыг бий болгох зорилготой.

Хүснэгт 1 – Ердийн бүтээгдэхүүний хэрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг сонгон авах маягт

Амьдралын мөчлөгийн үе шат	Хүрээлэн буй орчны оролт/гаралтын заагч					Бусад
	Эрчим хүч	Түүхий эд	Тархалт			
	Сэргээгдэх боломжтой	Сэргээгдэх боломжгүй	Ус	Агаар	Хөрс	
Түүхий эд гаргаж авах						
Үйлдвэрлэх						
Түгээх						
Ашиглах						
Хаях						

6.4.2 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг боловсруулах

6.4.2.1 Ерөнхий зүйл

Шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо орон нутгийн, бүс нутгийн дэлхий нийтийн холбогдолтой хүрээлэн буй орчны асуудлууд бололцоотой технологи болон эдийн засгийн чиг хандлагыг авч үзэх хэрэгтэй.

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийг дараах нэр томъёогоор илэрхийлнэ.

- хүрээлэн буй орчны ба байгалийн баялагийн талаархи нөлөөлөл;
- бодитоор хэрэгжих боломжгүй тохиолдолд хүрээлэн буй орчинд ялгарах гэх мэт хүрээлэн буй орчны хандлагууд;

Онцлог үйл ажиллагаа эсвэл батлагдаагүй үйлдвэрлэлийн аргыг хэрэглэх явдлыг шууд ба шууд бусаар шаардах буюу хориглож буй шалгуур үзүүлэлтийг хүчингүй болговол зохино. Тухайн зүйлийн аливаа хориглолт нь ИСО 14020 стандартын 3-р зарчимын дагуу шинжлэх ухааны аргачлалд үндэслэсэн байх хэрэгтэй. Эрсдэлийн үнэлгээ гэх мэт арга нь ийм тохиолдолд ашигтай мэдээлэл болж болох юм.

6.4.2.2 Хүрээлэн буй орчны нөлөөллийг багасгахад хамгийн их холбогдолтой газар нутгийн тодорхойлолт

Эко тэмдэглээний байгууллага нь ангилалд хамрагдсан бүтээгдэхүүнүүдийн хоорондын хүрээлэн буй орчны нөлөөллийн ялгаа байгаа тохиолдолд бүтээгдэхүүний амьдарлын мөчлөгийн үе шатыг тодорхойлно. Сонгон авсан бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт нь бүтээгдэхүүний хоорондын ялгаанд холбогдолтой байх түүнийг илэрхийлж байхын тулд онцлог бүтээгдэхүүнд зориулсан мэдээ, баримтын хамрах хүрээ хувирамтгай байдалд дүн шинжилгээ хийнэ.

6.4.2.3 Тоон ба чанарын индекс хэрэглэх

Эко тэмдэглэгээний байгууллага сонгон авсан хүрээлэн буй орчны шаардлагуудад тооцоолох хүчин зүйлүүдийг хэрэглэхдээ тоон ба чанарын индексийг зөв авч үзэх хэрэгтэй. Тооцоолох хүчин зүйл бүрийн шалтгааныг тодорхой тайлбарлаж баталсан байвал зохино.

6.4.2.4 Шалгуур үзүүлэлт бүрд холбогдох тоон хэмжээг тодорхойлох

Эко тэмдэглээний байгууллага нь сонгон авсан хүрээлэн буй орчны чиг хандлагад хамгийн их нөлөөлж байгаа шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон тохиолдолд эко тэмдэглэгээний байгууллага нь тэдгээрт тоон хэмжээ тогтооно. Эдгээр хэмжээ нь хамгийн бага хэмжээг илэрхийлж болох бөгөөд дээд хязгаарын түвшин нь хэмжээсний цэгүүд бүхий систем болон бусад тохирох зүйлүүдээс хэтрэхгүй байна.

6.4.2.5 Сорилтын арга, заавар, сорилтын лабораторийн үр дүнг тодорхойлох

Сорилтын болон баталгаажуулалтын шаардлагууд нь бүтээгдэхүүний ангилалд тавих шаардлагыг боловсруулах үйл ажиллагаатай зэрэгцүүлэн авч үзнэ. Эдгээр сорилтын болон баталгаажуулалтын шаардлагуудын зохион бүтээлтийн, техникийн болон эдийн засгийн боломжийг маш анхааралтай авч үзэх хэрэгтэй. Эко тэмдэглэгээний байгууллага нь аливаа шалгуур үзүүлэлт буюу шинж чанарыг тодорхойлоход шаардлагатай сорилтын аргад иш таталт хийж өгөх бөгөөд сорилт

явуулах чадвартай лабораторийн боломжийг шалгаж байвал зохино. Сорилтын аргыг 5.10-рт заасны дагуу сонгон авна.

6.5 Бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг сонгох

Бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг сонгон авахдаа бүтээгдэхүүний зориулалтад зохих анхаарлыг хандуулна. Энэ нь зохион бүтцийн болон дүрслэлийн шинж чанараас илүү бүтээгдэхүүний үзүүлэлтийн нэр томъёололд чиглэгдэнэ.

Бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг тогтоохдоо дараах зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарын тодорхойлох;
- бүтээгдэхүүний зориулалтыг тодорхойл байгаа үндсэн үзүүлэлтийн элементүүдийг сонгох;
- ангилалд хамрагдаж буй бүх бүтээгдэхүүнд хэрэглэх боломжтой үндсэн үзүүлэлтийг магадлан нотлох;
- үзүүлэлтийн шаардагдах түвшинг тодорхойлох;

6.6 Үр дүнг тайлагнах ба хэвлэх

Бүтээгдэхүүний ангилал, бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт, бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарыг нэгэнт тогтоосон бол тэдгээрийг хэвлэвэл зохино. Сонгон авсан тайлангийн загварт дараах асуудлыг тусгасан мэдээлэл дагалдана. Үүнд:

- энэхүү олон улсын стандартад заасан хамрах хүрээ, зарчим, бодит хэрэгжилт ба шаардлагуудад нийцсэн ангилал, шалгуур үзүүлэлт шинж чанарыг тогтоох;
- шалгуур үзүүлэлт бол бодитой, батлагдах боломжтой байх;
- бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанар нь боломжтой гэдгийн баталгаажуулах арга;
- сонирхогч талууд нь үйл ажиллагаанд оролцох боломжоо илэрхийлсэн бөгөөд тэдний үзэл бодлыг тооцон авч үзнэ.

6.7 Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх

Бүтээгдэхүүнд хүрээлэн буй орчны тэмдгийг хэдийнээ олгочихсон тохиодолд шалгуур үзүүлэлтэд тавигдах нөхцлүүд нь хүчин төгөлдөр үйлчлэх он сар өдрийг тогтоохын тулд хэд хэдэн хүчин зүйлүүдийг тогтоох хэрэгтэй.

Эдгээр хүчин зүйлүүдэд дараах асуудлууд орно. Гэхдээ эдгээр асуудлуудаар хязгаарлаж болохгүй.

- дахин хянасан бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлттэй нийцэж байх зайлшгүй шаардлага;
- дахин хянасан шалгуур үзүүлэлттэй нийцүүлэхийн тулд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өөрчлөн засварлахад хамааралтай өөрчлөлтийн цар хүрээ, хугацааны сунгалт, төвөгшилтийн түвшин;
- тодорхой үйлдвэрлэгч зохион бүтээлт, үйл ажиллагаанд тохиолдох худалдааны санамсаргүй гарч ирэх давуу талаас зайлсхийх;
- гэрчилгээ эзэмшигчийн материалыг оруулах хэрэгцээ;
- худалдан авагчид очих хүртэлх нийлүүлэгчийн гинжин хэлхээнд одоо хүртэл мөрдөж буй хуучин шалгуур үзүүлэлтийн дагуу хүрээлэн буй орчны тэмдэг авсан бүтээгдэхүүний хувьд шаардлагатай ажлууд

- гэрээ эзэмшигчтэй зохих ёсоор зөвлөлдөх хугацаа;
- эко тэмдэглэгээний байгууллагын өөрчлөлтийг удирдан хийхэд гарах хүндрэлүүд;
- хууль тогтоомжийн шаардлагууд;
-

7 Баталгаажуулалт ба нийцэл

7.1 Ерөнхий зүйл

7-р бүлэг нь баталгаажуулалтын ба нийцлийн ерөнхий шаардлагуудыг тогтооно.

ТАЙЛБАР: ОУСБ/ОУЦТК-ын 65-р удирдамжийг иш татаж болно.

7.2 Үндсэн ойлголтууд

7.2.1 Ерөнхий зүйл

Хүрээлэн буй орчны тэмдгийг авах нөхцлүүд нь 7.2.2 ба 7.2.3-р зүйлд заасан элементүүдэд хуваагдана.

7.2.2 Ерөнхий зааврууд

Ерөнхий зааврууд нь хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагааг удирдана. Эдгээр ерөнхий зааврууд нь гэрчилгээ болон тэмдэг хэрэглэхэд олгох ерөнхий нөхцлүүдийг хянана. Ерөнхий зааврууд нь дараах зүйлүүдийг тусгах ба харин эдгээр зүйлүүдээр хязгаарлагдаж болохгүй.

- гэрчилгээ эзэмшигчийн ил тод байдал;
- гэрчилгээний эрхийг зогсоох, хүчингүй болгоход чиглэгдсэн нөхцлүүд;
- үл тохирол илэрсэн тохиолдолд залруулах үйл ажиллагааг авч явуулах журам;
- маргааныг шийдвэрлэх журам;
- сорилтын ба баталгааны журам;
- татварын бүтэц;
- лого хэрэглэх заавар

Ерөнхий зааварт орсонгэрчилгээг авах ба тэмдгийг хэрэглэхэдэ тавигдах урьдчилсан бүх шаардлагууд, бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлтүүд ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарууд зэрэг эдгээр шаардлагууд нь гэрчилгээ олгох ба тэмдгийг хэрэглэх үндэслэл болгон ашиглана.

7.2.3 Бүтээгдэхүүний ангилал бүрт хамаарах бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарууд

Бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанар нь бүтээгдэхүүний ангилал бүрт зориулсан хүрээлэн буй орчныг тэмдэглэх 1-р загварын хөтөлбөрийн техникийн шаардлагыг тогтооно.

7.3 Гэрчилгээ олгох

Эко тэмдэглээний байгууллага нь мэдүүлэгчийн гэрчилгээ олгох асуудлыг хариуцна. Эко тэмдэглээний байгууллага нь гэрчилгээ ба тэмдэг хэрэглэх эрхийг

олгохдоо гэрээгээр хүлээсэн үүргээс гадна дараах зүйлүүдийг заавал хангасан байна:

- мэдүүлэг нь хөтөлбөрийн ерөнхий заавартай нийцэж байх;
- бүтээгдэхүүн нь хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанарт нийцэж байгаа бүтээгдэхүүн нь ангилалдаа тохирсон байх;

Гэрчилгээ олгосноор гэрчилгээ эзэмшигчийн тэмдэг хэрэглэхийг албадахгүй.

Эко тэмдэглээний байгууллага нь тэмдэг хэрэглэх эрх авсан бүтээгдэхүүний жагсаалтыг гаргах хэрэгтэй.

7.4 Нийцлийг үнэлэх ба таниулах

7.4.1 Үндсэн зарчим

Бүтээгдэхүүн нь хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт ба бүтээгдэхүүний зориулалтын шинж чанартаа нийцэж байгааг үнэлэх, нийцлийг тухай бүр шалгаж нотлох аргачлал нь баримтжсан байх ба хөтөлбөрийг найдвартай хэрэгжүүлэхэд зохих ёсоор нарийн чанд байвал зохино.

Нийцлийн журмуудыг сонгон авах аргачлал нь нэг хөтөлбөрөөс нөгөөд ялгаатай байх гэх мэт олон хүчин зүйлүүд нөлөөлж болох юм.

7.4.2 Хяналт ба шалгалт

Эко тэмдэглээний байгууллага нь ерөнхи йзааврын дагуу (7.2.2-ыг үзэх) хөтөлбөрийн шаардлагуудыг дахин хянаж шаардлага бүртг шалгаж нотлоход тохиромжтой загварыг тодорхойлно. Шаардлагуудыг хянаж үзсэний дараа хяналт ба шалгалтын төлөвлөгөөг боловсруулна.

7.4.3 Шаардагдах баримт бичгүүд

Эко тэмдэглээний байгууллага нь хүрээлэн буй орчны болон бусад хууль тогтоомжтой нийцэж байх үүргийг мэдүүлэгчээс шаардана.

Эко тэмдэглээний байгууллага нь хөтөлбөрийн шаардлагад нийцэж байгаа мэдүүлэгчийн тохирлыг баримтаар магадлан нотолно. Бүх баримт мэдээ нь ил тод, чанарын баталгаатай байна.

Эко тэмдэглээний байгууллага нь шаардлагын дагуу хамгийн наад зах нь дараах баримт бичгийг бэлтгэсэн байна. Үүнд:

- бүтээгдэхүүний ангилал;
- бүтээгдэхүүний хүрээлэн буй орчны шалгуур үзүүлэлт;
- бүтээгдэхүүний зориулалтын шинж чанар;
- шалгуур үзүүлэлтийн хүчин төгөлдөр байх хугацаа;
- сорилтын ба магадлан нотлох аргууд;
- баталгаажуулалт ба журам тогтоох;
- үе шаттай дахин хянах шалгуур;
- тэмдэг олгоход үндэслэсэн нууц биш нотолгоо;
- хөтөлбөр боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр (жишээлбэл: татвар, засгийн газрын санхүүгийн дэмжлэг г.м);
- шаардлагад нийцсэн баталгаа.

7.4.4 Тохирлын мэдэгдэл

Хэрэв хөтөлбөр нь тухайн хөтөлбөрийн шаардлагад тохирсон өргөдөл гаргагчийн мэдэгдлийг хэрэглэхийг зөвшөөрч байвал тохирлын мэдэгдлийг ОУСБ/ОУЦТК-ын 22-р Удирдамж дагуу гаргана.

7.4 Нийцлийг хянах

Өргөдөл гаргачид гэрчилгээ олгосны дараа гэрчилгээ эзэмшигч нь шаардлагад нийцүүлэн үргэлжлүүлэн мөрдөхөд нөлөөлж болох аливаа өөрчлөлтийг эко тэмдэглэгээний байгууллагад мэдэгдэж байна.

Эко тэмдэглэгээний байгууллага нь бүтээгдэхүүн буюу түүнийг үйлдвэрлэх үйл явцад эерэгээр нөлөөлөх нийцлийн аливаа өөрчлөлтийг авч үзэх бөгөөд хэрэв шаардлагад нийцэхгүй байвал залруулах үйл ажиллагааг санаачлан авч хэрэгжүүлэхийг гэрчилгээ эзэмшигчээс шаардана.

Энэ бол хөтөлбөрийн шаардлагуудад нийцүүлэх арга хэмжээ авч байгаа гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага юм.

7.5 Тэмдгийн хамгаалалт

Эко тэмдэглэгээний байгууллага нь (жишээлбэл: баталгаажуулалтын тэмдэг эсвэл лого хэлбэр) хууль бусаар хэрэглэхээс урьдчилан сэргийлэх болон хөтөлбөрийн хэрэгжилтэнд олон нийтийг итгэлтэй байлгах үүднээс хүрээлэн буй орчны тэмдгийг хууль ёсоор хамгаалсан байна.

Эко тэмдэглэгээний байгууллага нь тэмдгийг зөв хэрэглэхэд чиглэгдсэн тодорхой, ил тод бодлоготой байна. Энэ бодлогоос гадуурхи аливаа өөр чиглэл нь гэрээнд зохих залруулга хийх, хүчингүй болгох үед тодорхойлогдоно.

Ном зүй

1. ОУСБ 14001, *Хүрээлэн буй орчны удирдлагын тогтолцоо - Хэрэглэх заавар*
2. ОУСБ/ОУЦТК 17025, *Калибровкийн ба сорилтын лабораторийн чадварыг үнэлэх ерөнхий шаардлагууд.*
3. ОУСБ/ОУЦТК Удирдамж 2:1996, *Стандартчилал, холбогдох үйл ажиллагаа – Ерөнхий тайлбар толь.*
4. ОУСБ/ОУЦТК Удирдамж 22:1997, *Нийлүүлэгчийн тохирлын мэдэгдэлд тавигдах ерөнхий шаардлагууд.*
5. ОУСБ/ОУЦТК Удирдамж 65:1996, *Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах байгууллагад тавигдах ерөнхий шаардлагууд.*

ТӨГСӨВ.